

**“1990 ОНЫ АРДЧИЛСАН ХУВЬСГАЛД МОНГОЛЫН
ОЮУТНЫ ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ**

Д.Сүхбаатар МУИС-ийн багш, доктор (Ph.D)
Б.Ринчинноров МУИС-ийн түүхийн III ангийн оюутан

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд 1990 оны ардчилсан хувьсгалд монголын оюутнуудын гүйцэтгэсэн үүрэг мөн социалист системийн задралд Унгар, Польш, Чехословак, Хятадын оюутнууд хэрхэн оролцсон үр дүнгийн талаар архивын баримт, судалгааны зохиолуудад тулгуурлан хариулт өгөхийг хичээсэн болно.

Түлхүүр үг: Социализм, оюутан, МХЗЭ

*Залуус аа, оюутнуудаа
Хийморио сэргээж, бамбараа асаацгаая
Залуус аа, оюутнуудаа
Хүчээ нэгтгэж, хөх тэнгэрийн улсаа
мандуулцгаая
(1990 оны МОХ-ны сүлд дуунаас)*

Дэлхийн II дайны төгсгөлд, ялагч гүрэн болон тодрон гарч ирсэн ЗХУ-аар толгойлуулсан дэлхийн 15 орныг багтаасан эдийн засаг, улс төрийн социалист систем бүрэлдэн бий болжээ. Гэвч социалист системд багтсан улс үндэстнүүдэд 1956 онд Унгарт, 1968 онд Чехословакт, 1970-аад онд Польшид социализмийн эсрэг хөдөлгөөн өрнөсөн бөгөөд гол хүч нь оюутан залуучууд байжээ. Энэ нь “СОЦИАЛИЗМ” нурах үндэс суурь, эхлэлийг тавьж өгсөн байна. Мөн социалист системийн улсуудаас гадна капиталист хөгжлийн замаар замнаж байсан БНСУ-д оюутны бослого гарч нийгмийн болж бүтэхгүй байгаа зүйлийг өөрчлөхийн төлөө тэмцэж үр дүнд хүрч байсныг бид солонгосын түүхнээс мэдэж болно. 1989 онд Хятадад дэлхий нийтийн анхаарлыг татсан оюутны тэмцэл болж, бослогод оролцсон 20000 оюутныг Тянь-Ань-Мины талбай дээр нэг шөнийн дотор устгаж оюутны хөдөлгөөнийг дарсан байдаг. Оюунлаг оюутнуудын хөдөлгөөнийг хэдийгээр цус урсган дарсан ч үүнээс ч хүчтэй дараагийн хөдөлгөөн гарна гэдгийг хөшүүн царцанги коммунист засаглалд мэдрүүлжээ. Дарангуйлал дарангуйлалыг л бий болгодгийг өчигдөрийн түүх тэдэнд сануулж байв. Хятадын удирдагчид оюутан залуучуудын шаардлагаас ганц нэгийг нь яаравчлан хэрэгжүүлэх алхам хийж эхлэв. Жил бүрийн цуст аллага болсон өдөр өндөржүүлсэн байдал зарлаж дараа дараагийн эдийн засгийн хүрээн дэхь ардчилсан алхамыг эрчимжүүлж байлаа. Эдүгээ дэлхийн

олон улс XXI зууныг Хятадын зуун хэмээн хүлээн зөвшөөрөх эх үндсийг оюутнуудын тэмцэл тавьж өгсөн гэлтэй байна.

Тэгвэл Монгол улсад тусгаар тогтнолыг бүрэн утгаар нь авчирсан 1990 оны ардчилсан хувьсгалд МОХ, оюутан залуучууд ямар үүрэг гүйцэтгэв?

XX зууны 80-аад он болоход Монголд ч бусад социалист орнуудад ч ЗХУ-ын бүхнийг ганцаар шийддэг, дээрэнгүй гадаад бодлогыг шүүмжлэх болсон юм. Гэвч өөрчлөн байгуулалтыг тэд эхлэж болохгүйгээ сайтар мэдэж байв. Унгарт, Чехословакт, Польшид болсон цуст түүхийг тэд мартаагүй. Тийм ч учраас ЗХУ-аас өөрчлөлт шинэчлэлт эхлэхийг хүлээж байлаа. 1987 онд ЗХУ-ын удирдагч М.С.Горбачёв социалист систем зогсонги байдалд орсонд дүн шинжилгээ хийж өөрчлөн байгуулалт буюу “перестройка”-гаар асуудлыг шийдэх боломжтой хэмээн үзсэн нь социалист хэмээгдэх улс орнуудад хувьсгалт маягийн хөдөлгөөн өрнөх боломжийг нээж өгчээ. Социалист систем хоромхон зуурт задран унав.

Нэг нийгмээс нөгөөд шилжсэн монгол дахь хувьсгал нь бусад орнуудыг бодвол ихээхэн өвөрмөц онцлогтой байв. Түүнчлэн олон улсын хүрээлэл, гадаад орчны нөлөөлөл ч мөн хүчтэй байв.¹ Аливаа их үйл хэрэг нь гадаад, дотоод гүн гүнзгий шалтгаан нөхцөлтэй, урьд өмнөх үе болон ирээдүйтэй нягт холбоотой байдаг билээ.

Монголд ардчилсан хөдөлгөөн эхлээд социализмын өөрийнх нь хүрээнд, дараа нь монголын нийгмийг тогтолцооных нь хувьд бүрмөсөн эвдэн өөрчлөх замд эргэлт буцалтгүй шилжсэн юм. Монголд ардчилал хэрхэн өрнөв оюутнууд ямар үүрэг гүйцэтгэснийг тодруулья.

МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал хуралдаж “Эдийн засаг, улс төрийн систем, нийгэм, оюун санааны хүрээг бүхэлд нь хамарсан өөрчлөн байгуулалт хийх нь нам, ард түмний хойшлуулшгүй зорилт болж байна² гэж үзсэн нь монголчуудад хүлээлт үүсгэжээ. Гэвч бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх тал дээр МАХН дорвитой алхам хийхгүй байсан нь залуучууд оюутныг өөрчлөн байгуулалтыг хурдасгах алхамд эргэлт буцалтгүй оруулсан байна. Үүнээс үүдэн монголын нийгмийн амьдралд өөрчлөлт гарч нам, олон нийтийн байгууллагууд дүрэм журмаа өөрчилж шинэчлэл хийж эхэлсэн байна.

¹ Н.Жамбалсүрэн Ц.Нүүдэл Монголын түүх (ерээд он) УБ., 1999 5 тал

² “1990 оны ардчилсан хөдөлгөөний түүхэнд холбогдох баримт бичгүүд” эмхэтгэсэн Ж.Заанхүү УБ., 2004 6 тал

Улмаар МХЗЭ-ийн Төв Хорооны II бүгд хурал: “Оюутны холбоог бие даалгаж үйл ажиллагааг нь өөрчлөх шаардлагатай байна³” гэж заажээ. Ийм учраас МОХ нь МХЗЭ-д харьяалагдаж МАХН-ын нийгмийн бааз суурь болж байсан өнгөрсөн үеэс татгалзсанаараа өөрийнхөө зорилгыг Монгол улсын нийгмийн хөгжлийн дэвшилтэй уялдуулан бие даан тодорхойлж үйл ажиллагаа явуулах болсон байна. 1990 оны 2р сарын 21ны өдөр МОХ-ын тэргүүлэгчдийн хуралдсан V хурлаар оюутны байгууллагыг өөрсдийнх нь байгууллага болгох, ардчилал тийш хөтлөх баримтлалын үндсэн чиглэлийг боловсруулахдаа олон нийтийн улс төрийн байгууллага, санхүүгийн хувьд бие даасан байх, холбооны үндсэн дээр ажиллах удирдах байгууллагад өөр байгууллагын гишүүнийг сонгохгүй байхаас гадна төрөлжсөн холбоодтой байлгаж үйл ажиллагааг нь бүхэлд нь өөрчлөх нь зүйтэй⁴ хэмээн үзжээ.

1989 оны 11 р сард залуу уран бүтээлчдийн улсын II зөвлөгөөн болсон нь МоАХ үүсэх эх үндсийг тавьжээ. Уг зөвлөгөөнд оролцсон залуучууд өөрчлөн байгуулалтыг хурдасгахын тулд МАХН-ын явуулж буй бодлогод шүүмжлэлтэй хандан өөрчлөн шинэчлэж амжилтанд хүрнэ хэмээн үзжээ. Ийм учраас тэдний анхны тэмцэл бол жагсаал цуглаан байх ёстой гэсэн нэгдмэл саналтай болсон байна. Улаанбаатар хотод жагсаал цуглаан хийх бүхий л боломжийг хангаж байх энэ хооронд 1989 оны 12 дугаар сарын - нд Ховд аймагт Ховдын багшийн дээд сургуулийн оюутнууд “МАХН-ын УТТ-г огцрохыг шаардаж” анхныхаа жагсаалыг хийсэн байдаг. Монголд 70 гаруй жил тогтсон социализмын хана ганхах эхний том цохилтыг ийнхүү оюутнууд эхэлсэн байдаг юм. Ер нь оюутанд нэг талаасаа алдах юм байдаггүй мөн залуу халуун насны мөнхийн дагуул болсон зориг, зорьсондоо хүрэх гэсэн туйлбартай зан байдаг билээ.

1989 оны 12 дугаар сарын 10-нд олон улсын хүний эрхийн өдөр МоАХ-ны анхны цуглаан жагсаал болжээ. Энэ цуглаанд оюутны холбоог төлөөлөөгүй ч олон арван оюутнууд сэтгэлийнхээ дуудлагаар оролцсон юм. Энэ цуглаанд “Ардчилал бидний зорилт”, “хүний эрхийг эрхэмлэн дээдэлье” уриа лоозонтойгоор жагссан байна. Монгол дахь өөрчлөн байгуулалтын давлагаа улам эрч хүчээ авч энэ жагсаалаас долоохон хоногийн дараахоёр дахь том жагсаал өрнөлөө. Энэ жагсаалд 2000 гаруй хүн оролцож “МАХН бол нийгмийн удирдан чиглүүлэгч хүчин мөн” гэсэн нэр томъёог БНМАУ-ын Үндсэн хуулиас хасахыг шаарджээ. Энэ цуглаанд оюутан залуучууд олон

³ Мөн тэнд 10 тал

⁴ Д.Сүхбаатар, З.Баасанжав Монголын оюутны байгууллага “Өчигдөр өнөөдөр” УБ., 2002 28 тал

мянгаараа оролцсон юм. Удаж төдөлгүй 1990 оны 1 дүгээр сарын 14 нд гурав дахь цуглаан болж 10000 гаруй хүн оролцсоны 50 хувь нь оюутнууд байсан. Энэ бүх үйл явц өрнөхийн хэрээр МОХ идэвхжиж онц 4 р бага хурлаа 1990 оны 3 дүгээр сард хуралдуулав. Уг хурлаас “МОХ нь МХЗЭ-д харьяалагдаж МАХН-ын нийгмийн бааз суурь болж байсан өнгөрсөн үеэс татгалзсанаа тунхаглаж, бие даан үйл ажиллагаагаа явуулах болсон байна.”⁵

Түүхэн баримтуудыг сөхвөл МОХ шинэчлэх үйл явцад маш нарийн төлөвлөгөөтэйгээр оролцож байсан байдаг. Тухайлбал МХЗЭ-тэй хамтран “Залуус” оюутны клубыг нээн ажиллуулахын зэрэгцээ “ХХ зуун” оюутны улс төрийн ярилцлагын төвийг МУИС, ПТДС, ХААДС, Дарханы техникум болон Прага, Братислав, Москва, Ленинград, Свердловск зэрэг хотын сургуулиудад суралцаж байсан 13 оюутны бүрэлдэхүүнтэйгээр⁶ байгуулж үйл ажиллагааныхаа хүрээг тэлж байв. Оюутны энэхүү төвөөс И.В.Сталины хөшөөны талаар санал асуулга явуулж буулгах шийдвэр гаргаж хэрэгжүүлж байв. МОХ нь МоАХ-той нэгдэн МАХН-ын нийгмийг удирдан чиглүүлэгч заалтаас татгалзах, УТТ-г бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах шийдвэр гаргуулж байсан түүхтэй. Монголын оюутнуудыг зохион байгуулж чадварлаг удирдсан лидерүүд нь Л.Болд /МОХ/, Д.Баясгалан /ПТДС/, Д.Рэнцэнжавхай /МУИС/, Дарь.Сүхбаатар /УБДС/, С.Эрдэнэцогт /ХоБДС/, Ц.Мөнхтөр /ХоБДС/ зэрэг итгэл үнэмшилээрээ тэргүүлж байсан залуучууд байв. Оюутнууд зөвхөн люмпен маягаар тэмцэхийг хүссэнгүй төр засагт дуугаа хүргэж, олон мянган оюутнуудынхаа эрх ашгийг хамгаалах алхамыг хийж эхэлжээ.

1990 оны 7 дугаар сарын 7-нд ГСМОХ-ны анхдугаар бага хурал хуралдаж БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчид, БНМАУ-ын улс төрийн бүх намуудад хандаж мэдэгдэл гаргав. “Монгол дахь . . . хувьсгалт үйл явцад монголын оюутнууд ямагт идэвхтэй үүрэг гүйцэтгэж ирсэн. Монголын хагас бум шахам оюутнууд дэлхийн бусад орны оюутнуудын адил нийгмийн салшгүй нэгэн бүрэлдэхүүн хэсэг юм. . . .” хэмээгээд БНМАУ-ын АИХ-д 2, УБХ-д 1 суудал МОХ-нд олгохыг шаардсан байна. Ийм өндөр шаардлага тавих оюуны эх үүсвэр нь өрнөдийн орнууд дахь оюутны байгууллагуудын ардчилалын төлөөх тэмцлийн нөлөө байлаа. МОХ Прагаар төвлөсөн Олон улсын

⁵ Д.Сүхбаатар, З.Баасанжав Монголын оюутны байгууллага “Өчигдөр өнөөдөр” УБ., 2002 43 тал

⁶ Д.Сүхбаатар, З.Баасанжав Монголын оюутны байгууллага “Өчигдөр өнөөдөр” УБ., 2002 44 тал

оюутны холбооны жинхэнэ гишүүн байхын дээр Хонконгоор төвлөсөн Ази номхон далайн оюутны холбооны гишүүн, Брюсселиэр төвлөсөн Олон улсын спортын оюутны холбооны гишүүн, Копенгагенаар төвлөсөн Олон улсын аялал жуулчлалын холбооны хамтрагч, Женевээр төвлөсөн НҮБ-ын төлөө Олон улсын оюутны холбооны хамтрагч зэрэг 60 гаруй орны 100 шахам үндэстний оюутны хөдөлгөөний байгууллагатай хамтран ажиллаж байсан юм. Өрнөдийн оюутны ардчилалын төлөөх тэмцлийн нөлөөгөөр монголын оюутнууд нь тэмцлийнхээ хэлбэрийг оюунлаг замаар сонгосон нь амжилтанд хүрч байлаа. 1990 оны монгол дахь ардчилсан хувьсгалын торгон агшин эгзэгтэй үед оюутнуудын шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байсан тухай энэ өгүүлэлд дурьдахгүй өнгөрч болохгүй санагдана.

1990 оны 3 дугаар сарын 7-нд МоАХ-ноос өлсгөлөн зарлав. 3-р сарын 9 болоход нөхцөл байдал улам хурцадсаар байлаа. Талбай дээр байсан хүмүүсийн уур амьсгал эрс өөрчлөгдөж өлсөгчдийг буруутгах тал уруу эргэж эхэлсэн юм. Энэ уур амьсгалыг мэдэрсэн МАХН-ын төв хороо, ЗГ-ын зарим гишүүд улс оронд цэрэг цагдаагийн хүчээр онц байдал тогтоох тухай хуулийн төслийг боловсруулан бэлэн болгосон байв. Одоо зөвхөн хэлэлцээд шийдвэр гаргах л үлдсэн байв. Өлсөгчдөд энэ аймшигтай мэдээлэл ар араасаа цуван ирж байлаа. Энэ түүхэн үед “талбайн зүүн хойноос гэнэт олон мянган жагсагчид гарч ирэв. Энэ бол оюутнууд өлсөгчдийг дэмжин жагсан орж ирж байгаа нь тэр. Дайны талбарт ялагдал хүлээж үхлийн цохилтоо хүлээж байсан хүмүүст гэнэтийн хүч тэнгэрээс буух мэт үнэндээ авралын од л байсан юм шүү” гэж УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл 20 жилийн өмнөх хамгийн хүнд үеэ дурсахдаа оюутнууд маань ингэж л тэмцэгчдийг дэмжсэн юм” гэж билээ. Үнэхээр ч олон мянган оюутны энэ жагсаал МАХН-ын Төв Хороонд нөлөөлсөн юм. 3-р сарын 9 ны орой МАХН-ын төв хорооны УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох болсноо мэдэгджээ. 3 өдөр 2 шөнийн турш үргэлжилсэн улстөрийн өлсгөлөн оюунлаг оюутнуудын дэмжлэгтэйгээр 23.00 цагт зогсож зорьсондоо хүрчээ.

Эцэст нь дүгнэхэд:

1990 оны Ардчилсан хувьсгалд оюутнууд оролцож түүхэн үүргээ гүйцэтгэсэн байдаг. Түүнд тухайн үеийн МОХ, оюутнууд өөрийн бололцооны хирээр оролцжээ.

⁷ Боловсрол телевизэд УИХ-ын гишүүн Э.Бат-Үүлийн өгсөн ярилцлагаас

Одоогийн МОХ оюутнуудынхаа төлөө үйл ажиллагаа явуулж байхад тэр үед улс орны эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэх шаардлага гарчээ. Судалгаан дээрээс үндэслэн дараах бодомжуудад хүрч байна.

- МОХ шилжилтийн эгзэгтэй үед улс орны ирээдүй, ардчилал, хүний эрх, эрх чөлөөний төлөө өөрт байсан бүхий л боломжийг ашигласан байна.
- МОХ, монголын оюунлаг залуучууд Ардчилсан хувьсгалыг анхнаас нь дэмжиж, үйл ажиллагаанд нь идэвхийлэн оролцож шинээр бий болж буй монголын ардчилсан холбоо, хөдөлгөөнүүдийг үүсгэн санаачилж, хамтран тэмцэж, өлсөх үед нь өлсөж, жагсах үед нь жагсаж байсан нь архивын баримтаас нотлогдож байна.
- Социалист системийн болон капиталист хөгжлийн замаар замнаж байсан улс орнуудад тохиолдсон бослого хөдөлгөөнүүдэд оюутан залуучууд идэвхтэй оролцсон байна. Зүй тогтлын гэмээр энэ үзэгдэл 1989 онд монголд өрнөсөн Ардчилсан хувьсгалд тухайн үеийн МОХ, оюутан залуучууд идэвх санаачлага гарган шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байв.
- Олон улсын болон Монголд өрнөсөн Ардчилсан хувьсгалын практикаас харахад нийгмийн болж бүтэхгүй, эрээн барааныг нийгмийн оюунлаг хэсэг болсон оюутан залуучууд харснаар тэд залуу хүний зориг зүрхээр шууд тэмцэж чаддаг. Мөн зорилгодоо туйлбартай зогсож чаддаг юм байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.
- Барууны оюутнуудтай харьцсан харилцаа нь Монголын оюутнуудад нөлөө үзүүлсэн.
- Аливаа тэмцэлд оюутан, залуучуудын түрлэг орсон бол үр дүнд хүрдэг юм байна.

Abstract

This article tells about role of students about Mongolian democratic revolution 1990 also I tried to put toward proposal in this archive and academic paper.

Эшлэл, зүүлт

1. "1990 оны ардчилсан хөдөлгөөний түүхэнд холбогдох баримт бичгүүд" эмхэтгэсэн Ж.Заанхүү УБ., 2004
2. Н.Жамбалсүрэн Ц.Нүүдэл Монголын түүх (ерээд он) УБ., 1999
3. Д.Сүхбаатар, З.Баасанжав Монголын оюутны байгууллага "Өчигдөр өнөөдөр" УБ., 2002
4. МоАХ-ны анхдугаар их хурал УБ., 1990
5. Ө.Чулуунбилэг, Ө.Алтансүх XX зуун ба монголын оюутны хөдөлгөөний түүхэн замнал УБ., 2001